



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 09 сарын 08 өдөр

Дугаар 352

Улаанбаатар хот

О.Даваасамбууг ажилд томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 25 дугаар зүйл, “Геологийн төв лаборатори” төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийн 7.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2021 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн 01/1927 дугаар албан бичиг болон Авлигатай тэмцэх газрын 2021 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн 05/8874 дүгээр албан бичгээр ирүүлсэн саналыг харгалзан “Геологийн төв лаборатори” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлаар Отгонбаярын Даваасамбууг 2021 оны 09 дүгээр сарын 08-ны өдрөөс эхлэн томилсугай.

2. О.Даваасамбуутай контрактыг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132001427

\Huraldaanii material\2021 on\2021.09.08 14-r huraldaan.docx